

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГ ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ
/2021.01.04-2021.03.22/**

2021 оны 03 дугаар сарын 22-ны өдөр

Багануур дүүрэг

“Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар нийт 53 албан бичиг ирснээс, хариутай бичиг 23, хариугүй бичиг 30 байгаагаас Удирдлагад 3, Захиргааны албанд 42, Үйлдвэрлэл, технологийн албанд 8 албан бичиг хуваарилагдан тус тус шийдвэрлэгдсэн. Мэргэжилтнүүд хариуцсан үйл ажиллагааны чиглэлээр өөрсөддөө хуваарилагдсан албан бичгээ түргэн шуурхай, чанартай шийдвэрлэж байна.

Албан бичгийн эхийг eDoc программаар боловсруулж хэвшсэн. Албан бичгийн шийдвэрлэлтэд eDoc программын модулиудыг (эргэн танилцуулах, эргэн танилцуулах хэлбэр сонгох, хариутай бичгийн хариу сонгох, хамтран шийдвэрлэх) бүрэн ашиглахыг зорьж байна. Хариутай, хариугүй бичгийн шийдвэрлэлт 100%, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 100%-тай байна.

Нийслэлийн Архивын газраас өгсөн чиглэлийн дагуу, Э-токен төхөөрөмж авахад шаардлагатай бичиг баримтуудыг зааврын дагуу бүрдүүлж Газрын дарга болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар Үндэсний Дата төвийн баталгаажуулсан 2 тоон гарын үсгийн гэрчилгээг хүлээн авч үйл ажиллагаанд ашиглаж жигдэрсэн.


Санхүүгийн үйл ажиллагаанд тоон гарын үсэг ашиглах шаардлагын улмаас Нягтлан бодогчид тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлтийг 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 225 дугаартай албан бичгээр Үндэсний Дата төвд хүргүүлээд байна.

Манай байгууллагаас 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар харилцан холбоотой ажилладаг яам, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, албан байгууллагуудад нийт 39 албан бичиг явуулсан байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулан графикаар харуулав.

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧИГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2020 оны 01 дүгээр улирлыг, 2021 оны 01 дүгээр улиралтай харьцуулахад/



**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

/2020 оны 01-р улирлыг, 2021 оны 01-р улиралтай харьцуулахад, тоон үзүүлэлтээр/


№	Нийт ирсэн бичиг	Хариутай бичгийн тоо	Хариугүй бичгийн тоо	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа/хоног	Явуулсан бичиг
2020 оны 1-р улирал	55	18	37	3.75	45
2021 оны 1-р улирал	53	23	30	2.18	39

Албан бичгийг хамгийн боломжит богино хугацаанд, чанартай шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд хариутай бичгийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх оны мөн үед 3.75 байсан бол энэ онд 2.18 хоног байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн зөрчил дутагдал, хугацаа хэтэрч хаагдаагүй болон хугацаа хэтэрч хаагдсан албан бичиг байхгүй.

ХЯНАСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:

БИЧИГ ХЭРЭГ, АРХИВ, ГАДААД
ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХДУЛАМ